

June 23, 2017

ДБЭХС" ТӨХК-ийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүн



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовн баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**"ДБЭХС" ТӨХК-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН
/ДОР-ГАГ/2017/01-ГА/**



**Үйл ажиллагааны орлого нэмэгдэхийн хэрээр
арвилан хэмнэлтгүй ажилласан байна.**

**Чойбалсан хот
2017 он**

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын
алба

Дарга, Тэргүүлэх аудитор
Б.Болортуул
Утас: 70584203

Аудитын менежерийн
үүргийг түр орлон
гүйцэтгэгч Д.Нармандах
Утас: 70584207

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа
Утас: 70584207

Шинжээч
М.Ухаанбилэг,
Я.Зориг
Утас: 70584207

2017 оны 06 дугаар сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын
утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. Ажлын байрны тодорхойлолт, сонгон шалгаруулах журамд заасан шалгууруудыг хангасан ажилтанг авч ажиллуулаагүй байна.

1.1 “ДБЭХС” ТӨХК-ийн 2016 оны зорилтот түвшин биелсэн ч бүтээмж, чанарын удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.

1.2 Ажлын байрны тодорхойлолт, сонгон шалгаруулах журамд заасан шалгууруудыг хангасан ажилтанг авч ажиллуулаагүй байна.

II Бүлэг: “ДБЭХС” ТӨХК нь арвилан хэмнэлтгүй ажиллаж байна.

2.1 “ДБЭХС” ТӨХК нь 2015 оноос эхлэн улсын төсөвт ногдол ашиг төвлөрүүлж эхэлсэн байна.

2.2 Үйл ажиллагааны орлого нэмэгдэхийн хэрээр арвилан хэмнэлтгүй ажилласан байна.

2.3 “ДБЭХС” ТӨХК-ийн авлага 1087,0 хувиар зорилтот түвшнээс өссөн байна.

III Бүлэг: Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

3.1 Төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна.

3.2 Гэрээнд заагдсан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй гүйцэтгэгчид ногдуулах алдангийг тооцоогүй байна.

IV Бүлэг: Дотоод хяналтын алба нь хяналтын зарим чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.1 Хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

4.2 Дотоод хяналтын алба нь хяналтын зарим чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ

ЗӨВЛӨМЖ

АКТ

АЛБАН ШААРДЛАГА

ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗГ	Засгийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОХУ	Оросын Холбооны улс
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ИТА	Инженер техникийн ажилтан
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ДЭХ	Дулаан эрчим хүч
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ХҮХ	Хангамж үйлчилгээний хэлтэс
ДХА	Дотоод хяналтын алба
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ХАЦЭХ	Худалдан авалтын цахилгаан эрчим хүч
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТХЦ	Турбин хими цех
ТДЦ	Түлш дамжуулах цех
АШЗ	Агаарын шугамын засварчин
ТЭЦ	Тепло электро централь
ДХЦЭХ	Дулааны хэрэглээний цахилгаан эрчим хүч
ЦШС АШЗ	Цахилгаан шугам сүлжээ – Агаарын шугамын засварчин
ТДЦ ХМ	Түлш дамжуулах цех – хүнд механизм
ЦШС ДСХБ	Цахилгаан шугам сүлжээ – Дэд станц хуваарилах байгууламж
УЦ	Удирдах щит
ЦШС	Цахилгаан шугам сүлжээ
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
Квт.ц	Киловатт цаг
Г.кал	Гиго калори

ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
БО	Борлуулалтын орлого
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ДЦС	Дулааны цахилгаан станц
ТХА	Техник хяналтын алба
К-ДХА	Компьютер-Дулаан хэмжүүрийн автоматжуулалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

"ДБЭХС" ТӨХК-ийн үйл ажиллагаанд аудит хийж, үнэлгээ, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, арвилан хэмнэлттэй ажиллах, үр нөлөө, үр дүнг сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ.

- "ДБЭХС" ТӨХК-ийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй эсэх,
- "ДБЭХС" ТӨХК-ийн үйл ажиллагааны орлого, татаасыг үр ашигтай зарцуулсан эсэх,
- "ДБЭХС" ТӨХК-ийн худалдан авалт, гүйцэтгэл үр дүнтэй хэрэгжсэн эсэх,
- "ДБЭХС" ТӨХК-ийн үйл ажиллагаанд тавьж байгаа дотоод болон хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад "ДБЭХС" ТӨХК-ийн 2016 он, 2017 оны 05 дугаар сарын 01-ийг хүртэлх хүний нөөц, санхүү, худалдан авах үйл ажиллагаа, дотоод болон хөндлөнгийн хяналт болон бусад холбогдолтой баримт, материалд тулгуурлан гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл:

"ДБЭХС" ТӨХК нь Монгол Улсын Их Хурлын 2004 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 18 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны даргын 2006 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 143 тоот тушаал, Төрийн өмчийн хорооны 2008 оны 276, 405 дугаар тогтоолуудаар цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах, импортлох, эрчим хүч барилга угсралтын 8 тусгай зөвшөөрлийн хүрээнд Зүүн гурван аймгийн 36 сум, багийн 30646 айл өрх, 2586 аж, ахуйн нэгж, албан байгууллага,

уул уурхайн 15 ордын баяжуулах, олборлох үйлдвэрүүдийг цахилгаан эрчим хүчээр, Чойбалсан хотын 866 аж ахуйн нэгж, 4553 айл өрхийн хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тус тус хангах үйл ажиллагаа эрхэлж байна.

“ДБЭХС” ТӨХК нь 2016 онд 213,5 сая.кВт.ц цахилгаан эрчим хүч, 309,4 мян.Гкал дулааны эрчим хүчийг тус тус үйлдвэрлэн, 182,8 сая.кВт.ц цахилгаан эрчим хүч, 273,3 мян.Гкал дулааны эрчим хүчийг тус тус түгээн ажилласан байна.

“ДБЭХС” ТӨХК нь 2016 онд цахилгаан, дулааны эрчим хүч болон импортын цахилгааны борлуулалтын орлого 39,2 тэрбум төгрөг, үндсэн үйл ажиллагаанд 32,9 тэрбум.төгрөг, үйлдвэрлэлийн бус ажиллагаанд 2,6 тэрбум төгрөг нийт 35,5 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан байна.

Тус компани нь захиргаа удирдлага, хангамж үйлчилгээ, санхүү бүртгэлийн 3 хэлтэс, төлөвлөлтийн 1 хэсэг, дотоод хяналт, техник хяналт, инженер, хамгаалалт гэсэн 4 алба, түлш дамжуулах, зуух, турбин-хими, цахилгаан, компьютер-дулааны хэмжүүр автоматик, механик засвар, цахилгаан шугам, дулааны шугам сүлжээ нийт 8 цех, нэгжүүдийн зохион байгуулалттай, үйл ажиллагааны холимог бүтэцтэй ажил үйлчилгээ явуулж байна.

Компанийн хүний нөөцийн хувьд удирдлага 10, ИТА 123, ажилтан 469 нийт 602 орон тоотой ажиллаж байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журам, аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, ажиглалт хийх, судалгаа авах, үр дүнд шинжилгээ хийх, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, бодит байдал дээр оршин байгааг үзэх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- *Төсвийн тухай хууль*
- *Хөдөлмөрийн тухай хууль*
- *Эрчим хүчний тухай хууль*
- *Компанийн тухай хууль;*
- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль*
- *Татварын ерөнхий хууль*
- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль*
- *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль*
- *Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд*

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор

Б.Болортуул удирдаж, аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, шинжээч М.Ухаанбилэг, Я.Зориг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс эхэлж, 06 дугаар сарын 23-ны өдөр дуусган дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, төлбөрийн акт, албан шаардлага, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 4 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

I Бүлэг. Ажлын байрны тодорхойлолт, сонгон шалгаруулах журамд заасан шалгууруудыг хангасан ажилтанг авч ажиллуулаагүй байна.


1.1. “ДБЭХС” ТӨХК-ийн 2016 оны зорилтот түвшин биелсэн ч бүтээмж, чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлээгүй байна.

“ДБЭХС” ТӨХК нь хэрэглэгчийн хэрэгцээт цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн хэвийн найдвартай хангах зорилго тавин ажиллаж, 2016 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “сайн” үзүүлэлттэй дүгнэсэн байна.

“ДБЭХС” ТӨХК-ийн жилийн төлөвлөгөө, зорилтот түвшинг ТӨБЗГ-ын даргын тушаалаар батлуулдаг бөгөөд 2016, 2017 оны жилийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин болон 2016 оны биелэлтийг батлуулан ажилласан байна.

- 2016 онд ТЭЦ-ийн хэмжээнд 213500,4 мян.кВт.ц ЦЭХ боловсруулж, энэ нь төлөвлөгөөнөөс 32830,4 мян.кВт.ц-аар илүү буюу 18,2%-иар, 2015 онтой харьцуулахад 28787,3 мян.кВт.ц-аар буюу 15,6%-иар өссөн дүнтэй байна.
- Мөн 182847,9 мян.кВт.ц ЦЭХ түгээж, төлөвлөгөөнөөс 32617,9 мян.кВт.ц буюу 21,7%-иар, 273266 ГКал ДЭХ түгээж, төлөвлөгөөнөөс 40866 ГКал буюу 15,5 %-иар давж биелсэн. Өнгөрсөн онтой харьцуулахад цахилгаан эрчим хүчний түгээлт 17,6%-иар, дулааны эрчим хүчний түгээлт 6,2 %-иар тус тус өсч, дотоод хэрэглээний цахилгаан эрчим хүчийг 16,8%-иар төлөвлөж, Эрчим хүчний зохицуулах хороогоор батлуулан мөрдөж ажиллаж гүйцэтгэлээр 30652,5 мян.кВт.ц буюу 14,4%-иар биелж, төлөвлөснөөс 2,5 пункт, 2015 оноос 1,4 пунктээр, ЦЭХ-ний түгээлтийн алдагдлыг 6,1 хувиар төлөвлөж, гүйцэтгэлээр 3,2 хувь буюу 2,9 пунктээр буурч эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Дүрслэл №1. "ДБЭХС"-ийн 2016 оны ТЭЗҮ-ийн зорилтот түвшингийн биелэлт /Тоон үзүүлэлтээр/



Хүнэгт №1. "ДБЭХС"-ийн 2016 оны зорилтот түвшингийн биелэлт /хувиар/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он		Өсөлт, бууралт	
				Төлөв	Гүйц	Өөрчлөлт	Хувь
1	Боловсруулсан ЦЭХ	сая.кВтц	184.7	180.7	213.5	32.8	18.2%
2	ЦЭХ-ний түгээлт	сая. кВтц	163.9	180.5	224.5	44.0	24.4%
	Өөрийн түгээлт	сая. кВтц	155.5	150.2	182.8	32.6	21.7%
	ЦДҮС-ээс ХАЦЭХ	сая. кВтц	4.10	28.93	39.26	10.3	35.7%
	Импортын ЦЭХ	сая. кВтц	4.3	1.4	2.4	1.0	74.5%
	ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	257.2	232.4	273.3	40.9	17.6%
3	Дотоод хэрэгцээний ЦЭХ	хувь	15.80	16.80	14.40	(2.4)	-14.3%
4	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувь	7.2	6.1	3.2	(2.9)	-47.5%
5	Нийт орлого	сая.төг	27,747.4	30,611.0	39,210.6	8,599.6	28.1%
	Үүнээс:Борлуулалтын орлого	сая.төг	24,687.0	29,744.5	37,564.1	7,819.6	26.3%
6	Нийт зардал	сая.төг	26,104.3	29,788.6	35,490.4	5,701.8	19.1%
	Үүнээс:Удирдлагын зардал	сая.төг	327.6	189.7	218.2	28.5	15.0%
7	Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/	сая.төг	1,643.1	822.4	3,720.2	2,897.8	352.4%
8	Цэвэр ашиг /алдагдал /	сая.төг	1,580.1	740.2	3,620.2	2,880.1	389.1%
9	БО-ын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.9408	0.9731	0.9051	(0.068)	-7.0%
10	Нийт авлага	сая.төг	1,988.3	100.0	1,187.0	1,087.0	1087.0%
11	Нийт өглөг	сая.төг	19,043.9	12,000.0	11,829.3	170.7	101.4%
	Үүнээс : Богино хугацаат өглөг	сая.төг	1,412.5	800.0	1,304.4	504.4	63.1%

12	Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХ	сая.төг	4,007.1	6,458.1	6,163.7	(294.4)	-4.6%
13	Түлшний хувийн зарцуулалт ЦЭХ	гр/квтц	642.8	676.2	636.8	(39.4)	-5.8%
14	ДЭХ	кг/гкал	192.0	195.0	191.7	(3.3)	-1.7%
15	Аваар саатал	сая.төг	1.0	-	-	-	0.0%
16	Нийт ажиллагсдын тоо	тоо	596	602	615	13.0	2.2%
17	Нийт цалингийн сан	сая.төг	7,479.4	8,859.7	9,939.1	1,079.4	12.2%

Цахилгаан эрчим хүчний /ЦЭХ/ түгээлтийн алдагдал -47.5 хувь байгаа нь 2016 онд нийт ЦЭХ-ний 6.1 хувийг түгээлтийн алдагдал байна гэж төлөвлөж, гүйцэтгэлээр 3.2 хувь болж буурсан, дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч -14,5 хувьтай байгаа нь дотоод хэрэглээг хэмнэж ажилласантай холбоотой байна.

“ДБЭХС” ТӨХК-ийн үйлдвэрийн хүчин чадлыг 2016 оноос 100,0 хувь ашиглаж, 4 турбогенератор, 6 зуухыг зэрэг ажиллуулж эхэлсэнтэй холбогдуулан ажлын ачаалал ихэссэн гэж үздэг.

2016 онд нийт орон тоог 602 хүн байхаар төлөвлөсөн ч, ачаалал ихтэй турбин хими цех, түлш дамжуулах цех, зуухан цех, Дорнод салбарт 8 орон тоо, жирэмсний амралттай 5 хүний оронд хүн авч, нийт 13 орон тоог нэмж, 2017 онд давхардсан тоогоор 615 хүний орон тоотой ажиллаж байна. Нэмэгдсэн орон тоо:

- Турбин хими цех: Засварын мастер 1
- Түлш дамжуулах цех: Бульдозерийн жолооч 2, Турбины машинч 1
- Зуухан цех: Туслах машинч 1
- Дорнод салбарт: Нөмрөг, Хавирга, Ульхан боомтын байцаагч монтёр 3

Цаашид үйлдвэрийн өргөтгөл, хүчин чадлын ачаалалтай холбогдуулан орон тоо нэмэгдэх төлөвтэй байна.

Ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг Дарханы дулааны цахилгаан станц, Дулааны 3-р цахилгаан станцууд нь бүтээмж, чанарын удирдлагын ISO 9001:2008, 2010 стандартуудыг нэвтрүүлж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

- ISO 9001:2008-ын гол зорилго нь тухайн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэгчийн сэтгэл ханамжийг бий болгоход тогтмол чиглэдэг гэсэн баталгааг хэрэглэгчдэд өгөх явдал юм. ISO 9001:2008 нь үйлчилгээний тодорхой үр дүн, түвшинг үзүүлэхээс илүү тогтмол байдлыг хангахад чиглэсэн байдаг тул үйлдвэрлэж буй цахилгаан, эрчим хүч нь дүрэм, журмын шаардлага, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг бий болгохыг шаарддаг. Чанарын удирдлагын тогтолцоо, түүний хэрэгжилт нь хэрэглэгч төлсөн мөнгөний үнэ цэнийг авч байгаа гэж мэдрэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг чанарын түвшинд нийлүүлж байгаа эсэхээр тодорхойлогдоно. Мөн чанарын стандартын гэрчилгээ олгосон байгууллагаар чанарын зорилгоо хангаж байгаа эсэхэд тогтмол аудит хийлгэдэг байна.

Иймд дээрх стандартыг нэвтрүүлснээр хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг бий болгох, компанийн үйл ажиллагааны чанарыг сайжруулахад давуу талтай учраас цаашид “ДБЭХС” ТӨХК нь үйл ажиллагаандаа бүтээмж, чанарын удирдлагын олон улсын стандартуудыг нэвтрүүлэхийг зөвлөж байна.

1.2. Ажлын байрны тодорхойлолт, сонгон шалгаруулах журамд заасан шалгууруудыг хангасан ажилтанг авч ажиллуулаагүй байна.

“ДБЭХС” ТӨХК-ийн бүтэц, орон тоог ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар тогтоол, гүйцэтгэх захирлын 2016 оны 12-р сарын 02-ны А/310-р

тушаалаар 16 алба, хэлтэс, цех, тасаг, хэсэг, 602 ажилтны орон тоотой байхаар баталсан. Бүтэц, орон тоог батлахдаа “ДБЭХС” ТӨХК-ийн хэлтэс, алба, цех, тасаг, нэгжүүдээс шаардлагатай ажилтнуудын тоо, судалгааг авч нэгтгэн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ТУЗ бүрэн эрхийнхээ хүрээнд хянаж, баталсан байна.

Хүснэгт №2. “ДБЭХС” ТӨХК-ийн бүтэц, орон тоо” гүйцэтгэлээр

№	Компани, алба, хэлтэс, цех, хэсгийн нэр	2017 оны ажилтны орон тоо			Бүгд	
		Удирдлага	Ажилтан	ИТА	2016	2015
1.	“ДБЭХС” ТӨХК	2			2	2
2.	Захиргаа удирдлагын хэлтэс	1		5	6	6
3.	Санхүү бүртгэлийн хэлтэс	1		9	10	10
4.	Дотоод хяналтын алба	1		1	2	2
5.	Төлөвлөлтийн хэсэг	1		1	2	2
6.	Хангамж үйлчилгээний хэлтэс	1	6	4	11	11
7.	Инженерийн алба	1		11	12	12
8.	Техник хяналтын алба	1		4	5	5
9.	Хамгаалалтын алба		25		25	26
10.	Түлш дамжуулах цех		40	7	47	45
11.	Зуухан цех		78	8	86	86
12.	Турбин хими цех		57	9	66	66
13.	Цахилгаан цех		29	11	40	40
14.	К-ДХА цех		14	7	21	20
15.	Механик засварын цех		15	2	17	17
16.	Цахилгаан шугам сүлжээний цех		66	7	73	73
17.	Дулаан шугам сүлжээний цех		15	2	17	17
18.	Авто граж		25		25	24
19.	Дорнод салбар	1	37	16	54	51
20.	Сүхбаатар салбар	1	65	15	81	81
НИЙТ		11	472	119	602	596
БҮГД НИЙТ /2017 оны гүйцэтгэлээр/		11	485	119	615	596

Хүснэгтээс харахад ажиллагсдын тоо 2015-2017 онд нийт 19 хүнээр нэмэгдэж, бүтэц, орон тооны 2,0 хувийг удирдлага, 78,0 хувийг салбар, алба, цехийн ажилтнууд, 20,0 хувийг инженер, техникийн ажилтнууд эзэлж байна.

Аудитын явцад “ДБЭХС” ТӨХК-ийн ажил, үүргийн хуваарийг судалж, ажилчдаас санал асуулга авч үзэхэд турбин, түлш, зуухан цехэд 4 ээлжээр нийт 175 хүн ажиллахад ажлын ачаалал их, санал асуулгад оролцогчдын 18,0 хувь нь чиг үүргийн давхардал гардаг, 20,0 хувь нь шаардлагатай орон тоог нэмэх /үндсэн үйл ажиллагаа явуулдаг цех/ талаар нэмэлт санал хүсэлтээ илэрхийлсэн нь зарим албан тушаалд чиг үүргийн давхардал үүссэн, үндсэн үйл ажиллагаа явуулдаг турбин, зуух, түлш дамжуулах цехэд орон тооны дутагдал байгааг харуулж байна.

Дүрслэл №2, “Ажилтнуудаас авсан санал асуулгын дүн”

1. “ДБЭХС” ТӨХК-ийн бүтэц, орон тоо хүртээмжтэй түвшинд байна гэж үзэж байна уу?



- Санал асуулгад “ДБЭХС” ТӨХК-ийн цех, тасаг, хэлтэс, албадын нийт 175 албан хаагчид, ажилтнуудыг хамруулсан бөгөөд санал асуулгын дүнг нэгтгэсэн байдлаар харуулав.

Дээрх бүтэц, орон тооны асуудал нь Стандарт, хэмжил зүйн газар, Стандартчиллын үндэсний зөвлөл, Эрчим хүчний яам, холбогдох байгууллагуудаас баталсан дулааны цахилгаан станцын орон тооны талаар тогтсон стандарт байхгүй, “ДБЭХС” ТӨХК-ийн хэмжээнд бүтэц, орон тооны жишиг баримт бичиг, хүний нөөцийн бодлогын баримт бичиг байхгүй, мэргэжлийн байгууллагуудаар бүтэц орон тооны талаар хийлгэсэн тооцоо, судалгаа дутмаг байгаагаас шалтгаалж байна.

Тус хүний нөөцийн хувьд удирдлага 10, ИТА 123, ажилтан 482 нийт 615 хүний орон тоотой ба магистр 3, бакалавр 177, тусгай дунд 17, бүрэн дунд 395, бүрэн бус дунд 23 байгаагаас Монгол улсын зөвлөх инженер 2, мэргэшсэн инженер 7, мэргэшсэн нягтлан бодогч 2, мэргэшсэн төсөвчин 2 хүн тус тус ажиллаж байна.


Сул орон тоонд ажлын байрны сонгон шалгаруулалтыг хэрхэн зохион байгуулж байгаад дүн шинжилгээ, судалгаа хийж үзэхэд “ДБЭХС” ТӨХК-ийн “Боловсон хүчний нөөцийг судалж бүрдүүлэх, ажилд авах хүнийг сонгон шалгаруулах журам”-ын 3.3-ийн “а”¹, “в”²-д заасан дэгийг баримтлахгүй байна. Тухайлбал 2016, 2017 онуудад боловсон хүчнийг сонгон шалгаруулахдаа сул орон тооны талаар компанийн вэб сайт болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлээгүй, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран ажиллаагүй, ажилтныг сонгон шалгаруулсан тухай шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлээгүй, тухайн ажлын байрны шаардлага хангасан хүмүүсээс ярилцлага хийх, анхан шатны шалгалтыг зохион байгуулах журам алдагдсан байна

¹ 3.3-ын “а” – Шаардлагатай орон тоо, ажлын байр, түүнд тавигдах шаардлагын талаар компанийн вэб сайт болон орон нутгийн мэдээллийн хэрэгслээр зар тавих, аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажиллах замаар ажилд орохыг хүсэгчдийг бүртгэнэ.

² 3.3-ын “в” - Хүний нөөц, сургалтын мэргэжилтэн нэг орон тоон дээр тухай ажлын байрны шаардлага хангасан хүмүүсээс 2-3 хүнийг бүртгэн авч ярилцлага хийн анхан шатны шалгалт авч 85 хувиас дээш оноо авсан нэг хүнийг шалгаруулна. Харин ажлын дадлага туршлага шаардах ажлын байранд /токарьчин, бульдорзерийн жолооч г.м/ 2-3 хоног ажлын байранд нь туршиж ажиллуулсны дараа сонгон шалгаруулна. Сонгон шалгаруулалт дээр захиргаа удирдлагын хэлтсийн дарга, хөдөлмөрийн харилцаа, хуулийн мэргэжилтэн нар хяналт тавьж ажиллана.

Дүрслэл №3, “Ажилтнуудаас авсан санал асуулгын дүн”


5. Ажлын байрны сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулж байна уу?



- а. Хууль, журмын дагуу зохион байгуулдаг. (23)
- б. Нэг хүний буюу удирдлагын шийдвэрээр. (53)
- в. Мэдэхгүй (87)
- г. Тухайлбал: (7) Ил тод бус, мэргэжлийн бус хүн ажилд авдаг-1, Төрийн бус алба-1, Дарга нарын хүмүүс ордог-2, Ажлын байр зарладаггүй-2

Дүрслэл №4, “Ажилтнуудаас авсан санал асуулгын дүн”


6. Танил талын хүрээнд хамаатан садан, харилцан хамаарал бүхий хүмүүсийг ажилд авч байна уу?



- а. Тийм (110)
- б. Үгүй (34)
- в. Тухайлбал: (28) Мэдэхгүй-22, Боловсрол, ажлын туршлага харж авдаг-1, Байхыг үгүйсгэхгүй-1, Хангамжийн дарга-3, Заримдаа-1

Дүрслэл №5, “Ажилтнуудаас авсан санал асуулгын дүн”

7. Ажлын байрны тодорхойлолтод нийцээгүй (мэргэжил, боловсрол, тусгай шаардлагад нийцээгүй) хүнийг ажилд авсан тохиолдол байна уу?



- а. Тийм (85)
- б. Үгүй (49)
- г. Тухайлбал: (32) Мэдэхгүй-20, Мэргэжлийн бус ажилчид байдаг хэдий ч сургагч багшаар 2-3 сар дагалдаж, шалгалт өгдөг тул энэ асуудал биш-1, заримдаа-2, бие муутай хүн ажилд их орсон-1, ХҮХ-ийн дарга-8

- Санал асуулгын дүн: “Ажлын байрны сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулж байна уу?” гэсэн асуултад 51,0 хувь нь мэдэхгүй, 31,0 хувь нь нэг хүний буюу удирдлагын шийдвэрээр, “Танил талын хүрээнд хамаатан садан,

харилцан хамаарал бүхий хүмүүсийг ажилд авч байна уу?" гэсэн асуултад 64,0 хувь нь тийм, 16,0 хувь нь мэдэхгүй, заримдаа, ХҮХ-ийн дарга, "Ажлын байрны тодорхойлолтод нийцээгүй (мэргэжил, боловсрол, тусгай шаардлагад нийцээгүй) хүнийг ажилд авсан тохиолдол байна уу?" гэсэн асуултад 51,0 хувь нь тийм, 19,0 хувь нь мэдэхгүй, заримдаа, ХҮХ-ийн дарга гэж хариулсан.

Санал асуулгын дүнг нэгтгэж үзэхэд ажлын байрны сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулдаггүй, харилцан хамаарал бүхий, ажлын байрны тодорхойлолтод нийцээгүй иргэнийг ажилд авдаг гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Аудитын хугацаанд компанийн ажиллагсдын боловсрол, мэргэжлийн судалгаа гаргаж, ажлын байрны тодорхойлолтод заасан тусгай шалгууртай харьцуулан үзэхэд 2016, 2017 оны 05 дугаар сарын 01-ний хүртэлх хугацаанд ажлын байрны нөхцөл, шаардлага, шалгуурт нийцээгүй, мэргэжлийн бус иргэнийг дараах ажлын байруудад сонгож ажиллуулсан зөрчил илэрч байна. Үүнд:

Хүснэгт №3. Ажлын байрны тодорхойлолт, сонгон шалгаруулах журамд нийцээгүй албан хаагчдын нэрс

№	Овог, нэр	Албан тушаал	Шалгуур үзүүлэлт	Боловсрол, мэргэжил	Тайлбар
1.	Батсүх Гэрэлт-Оч	ХҮХ-ийн дарга	- Эрчим хүчний тоног төхөөрөмж, материал сэлбэгийн зориулалт, төрөл ангийг сайн мэддэг, дээд боловсролтой байх. - Үйлдвэрт ажиллаж буй нөөцөөс	Бүрэн дунд	Сонгон шалгаруулах журмын 2.3-ын "а" дахь заалтыг зөрчсөн. Дипломтой эсэх нь тодорхойгүй.
2.	Мөнхбаатар Мөнх-Эрдэнэ	ТДЦ ХМ-ын засварчин /дагалдан/	ТДЦ-ХМХ-ийн засварчин нь 18-аас дээш насны эрүүл мэндээр тэнцсэн, бүрэн дунд буюу түүнээс доошгүй түвшний боловсролтой, зохих курс төгссөн, техникийн анхны мэдэгдэхүүнтэй хүн байна.	Бүрэн дунд	Сонгон шалгаруулах журмын 3.3-ын "б"-д бүрэн дундаас дээш гэж заасан. Тусгай мэргэжил эзэмшээгүй.

Жич: Шалгуур үзүүлэлтийг гаргахдаа ажлын байрны тодорхойлолт, "Боловсон хүчний нөөцийг судалж бүрдүүлэх, ажилд авах хүнийг сонгон шалгаруулах журам"-ыг үндэслэл болгов.

Мэргэжлийн бус болон мэргэжил эзэмшээгүй иргэдийг авч ажиллуулж байгаа нь ажлын байрны тодорхойлолтод заасан тусгай шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Удирдах албан тушаалд /Хангамж, үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаал/ ажилтныг сонгон шалгаруулж, ажилд авахдаа үйлдвэрт ажиллаж буй инженер, мэргэжилтэн нараас эрхэлж буй ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж буй чадвар, удирдан зохион байгуулах авьяас, хувийн шинж чанар зэрэг үзүүлэлтээр нь шилж сонгон бүрдүүлээгүй нь "Боловсон хүний нөөцийг судалж бүрдүүлэх, ажилд авах хүний сонгон шалгаруулах журам"-ын 2.3-ын "а"³ дахь заалт, ТДЦ ХМ-ын засварчны албан тушаалд ажилчныг судалж, бүрдүүлж, сонгон шалгаруулж ажилд авахдаа тусгай мэргэжил эзэмшээгүй иргэнийг авч ажиллуулж

³ "Боловсон хүний нөөцийг судалж бүрдүүлэх, ажилд авах хүний сонгон шалгаруулах журам"-ын 2.3-ын "а"- Компанийн удирдах ажилтан /Захирлын зөвлөлийн гишүүд/ болон цехийн дарга нарын нөөцийг үйлдвэрт ажиллаж буй инженер, мэргэжилтэн нараас эрхэлж буй ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж буй чадвар, удирдан зохион байгуулах авьяас, хувийн шинж чанар зэрэг үзүүлэлтээр нь шилж сонгон бүрдүүлнэ.

байгаа нь журмын 2.3-ын “б”⁴, 3.3-ын “б”⁵ дахь заалт, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1⁶ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд: Ажлын байруудад ажлын байрны тодорхойлолт, сонгон шалгаруулах журамд заасан шалгуурыг хангасан ажилтанг авч ажиллуулах “Албан шаардлага”-ыг аудитаар хүргүүлж байна.

“ДБЭХС” ТӨХК-д 2016-2017 онд нийт 42 ажилтан шинээр ажилд орсон бөгөөд үүнээс 23 нь дээд, 9 нь бүрэн бус дунд, 10 нь тусгай дунд боловсролтой байна. Ажлын байрны тодорхойлолтын шаардлагад тусгай мэргэжил шаардагдах албан тушаалд мэргэжил, боловсрол тусгагдаагүй байгаа нь тухайн ажлын байр албан тушаалд бус тухайн хүнд тохирсон мэт ажиглагдаж байна. Одоогийн баталж, мөрдөж байгаа ажлын байрны тодорхойлолт нь агуулга, бүтцийн хувьд компанийн сонгон шалгаруулах журмаас агуулгын хувьд зөрүүтэй, бичилтийн хувьд алдаатай байгаа нь цаашид Монголын хүний нөөцийн институт⁷-ээс гаргасан зөвлөмжийн дагуу ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан гаргах шаардлага үүсэж байна.

Журмын 3.3-ын “б”-д “Компани нь бүрэн дундаас дээш боловсролтой, мэргэжлийн их, дээд, тусгай сургууль төгссөн хүмүүсээс шалгаруулж ажилд авна” гэж заасан нь 2017 оны 05 дугаар сарын байдлаар үйлдвэрийн хэмжээнд 395 ажилтан бүрэн дунд боловсролтой байгаа нь журмын тус заалтыг зөрчиж байгаа учраас журамд өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Иймд: Ажлын байрны тодорхойлолт, “Боловсон хүчнийг судалж бүрдүүлэх, ажилд авах хүнийг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн боловсруулах “албан шаардлага”-ыг аудитаар хүргүүлж байна.

Монголын хүний нөөцийн институтээс баримтлах бодлого, томоохон аж ахуйн нэгжүүдийн үзэж буйгаар 100-150 хүн тутамд 1 шилдэг хүний нөөцийн менежер ажиллуулахыг зөвлөдөг. Гэтэл “ДБЭХС” ТӨХК-ийн түвшинд 602 хүнд 1 хүний нөөцийн менежер байгаа нь зохистой харьцаа биш байна. Хүний нөөцийн менежер нь ажилтнуудыг шилж, сонгон шалгаруулах, ажлын байрны тодорхойлолт боловсруулах, ажилтнуудын сургалт, хөгжлийг зохион байгуулах, хувийн хэргийн баяжилтыг хийх, албан хаагчдын судалгаа, шинжилгээ /албан тушаал ахих, шагнал урамшуулал гэх мэт/ хийх зэрэг үндсэн чиг үүрэгтэй ажиллах ёстой. “ДБЭХС” ТӨХК-ийн хүний нөөцийн менежерт ногдох ажлын ачаалал их байгаагаас зарим чиг үүргээ хэрэгжүүлэхгүй орхигдуулж байгаа нь цаашид хүний нөөцийн менежерийн орон тоог нэмэгдүүлэх, эсвэл зарим чиг үүргийг бусад ажлын байрны тодорхойлолтод тусгах зэрэг хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Бид аудитын явцад ажилтнуудын хувийн хэргийн баяжилтыг хэрхэн зохион байгуулж байгааг үзэж шалгасан бөгөөд ажилтнуудын ажил байдлын тодорхойлолт, нэмэгдэл хуудас, хувь хүний намтар, шалгалт өгсөн тухай баримт, өргөдөл, шагналын

⁴ 2.3-ын “б” Үйлдвэрийн хэмжээнд ажил хариуцсан ажилтан /Горим, тооцоо, засвар зохицуулалт инженер г.м/, цехүүдийн инженер, бусад мэргэжилтэн, албан хаагчдын нөөцийг одоо ажиллаж буй их, дээд сургуульд суралцагсдаас гүйцэтгэх захирал, ерөнхий инженер, захиргаа удирдлагын хэлтсийн дарга, холбогдох алба, хэлтсийн дарга, хүний нөөцийн мэргэжилтэн нар хариуцан сонгон шалгаруулж бүрдүүлнэ.

⁵ 3.3-ын “б” – Компани нь бүрэн дундаас дээш боловсролтой, мэргэжлийн их, дээд, тусгай сургууль төгссөн хүмүүсээс шалгаруулж ажилд авна.

⁶ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэргэжил” гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг;

⁷ Монголын хүний нөөцийн институтээс гаргасан ажлын байрны тодорхойлолт боловсруулах зөвлөмж: <http://mhri.mn/news/3651/Ажлын+байрны+тодорхойлолт+боловсруулах+зөвлөмж>

жагсаалт, албан хаагчийн танилцуулга, албан тушаалын карт зэргийг хөтлөөгүй, дипломын хуулбар байхгүй нь хувийн хэргийн баяжилт хангалтгүй гэж үзэх үндэслэл болж байна. Цаашид Төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан 2004 оны 18 дугаар тогтоолын дагуу⁸ хөтөлж байхыг зөвлөж байна.

II. Бүлэг: “ДБЭХС” ТӨХК нь арвилан хэмнэлтгүй ажиллаж байна.

2.1 “ДБЭХС” ТӨХК нь 2015 оноос эхлэн улсын төсөвт орлого ногдол ашиг төвлөрүүлж эхэлсэн байна.

“ДБЭХС” ТӨХК нь 2015 оноос эхлэн 1,6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж эхэлсэн бөгөөд улсын төсвөөс 2,2 тэрбум төгрөгийн татаасыг авч байж үүссэн ашиг байна. Үүнээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ногдол ашиг 20,0 хувь буюу 316,0 сая төгрөг олгосон байна. “ДБЭХС” ТӨХК нь 2016 онд улсын төсвөөс татаас авалгүйгээр 3,6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж 2017 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 30,0 хувийн ногдол ашиг төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Хүснэгт № 4 “Орлогын судалгаа”

Үзүүлэлт	2013		2014		2015		2016	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зардал	18 135,1	20 089,9	20 72,0	22 530,5	24 231,5	26 104,3	29 788,6	35 490,3
Борлуулалт	13 310,1	14 621,5	16 318,7	18 597,2	20 803,1	24 228,2	29 603,3	37 258,8
Импортын орлого	260,6	306,2	367,9	348,7	418,1	458,7	141,1	305,2
Бусад орлого	300,0	1 116,8	793,6	1 383,8	810,2	860,4	866,4	1 646,5
Нийт орлого	13 870,7	16 044,6	17 480,2	20 329,8	22 031,5	25 547,4	30 611,0	39 210,6
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	-4 264,3	-4 045,2	-3 247,7	-2 200,6	-2 200,0	-556,8	822,3	3 720,2
Татаасын орлого	2 200,0	2 000,	2 200,0	2 200,0	2 200,0	2 200,0		
Нийт ашиг, алдагдал	-2 064,3	-2 045,2	-1 047,7	-688,1	0,00	1 643,1		
Татварын зардал					-	63,1	82,2	100,0
Татварын дараах ашиг					-	1 580,1	740,1	3 620,2

ТУЗ-ын 2016 оны баталсан орлогын зорилтот түвшинг 30,6 тэрбум төгрөгөөр баталснаас 39,2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж 8,6 тэрбум төгрөгөөр зорилтот түвшинг давуулан ажилласан байна.

Хүснэгт №5 “Борлуулалтын орлогын судалгаа”

№	Үйл ажиллагааны чиглэл	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он		Зөрүү	
				Гүйц	Төлөв	Гүйц	Гүйц	Төлөв
1	Цахилгаан	Борлуулалт	сая квтц	147.8	169.6	217.2	69,4	47,6
		Борлуулалтын орлого	сая төг	21 174.50	26 177.4	33 782.6	12608,1	7605,2
		Дундаж үнэ	төг/квтц	143.2	154.3	154.9	11,7	0,6
2	Дулаан	Борлуулалт	мГкал	257.2	232.4	273.3	16,1	40,9
		Борлуулалтын орлого	сая төг	3 053.78	3 425.9	3 476.3	422,5	50,4

⁸ “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-

		Дундаж үнэ	төг/Гкал	11 873.4	14 41.4	12 719.7	846,3	-2021,7
3	Импортын эрчим хүч	Борлуулалтын орлого	сая төг	458.71	141.2	305.2	153,5	164
4	Бусад	Борлуулалтын орлого	сая төг	860.5	866.5	1 646.6	786,1	780,1
	НИЙТ	Борлуулалтын орлого	сая төг	25 547.45	30 11.0	39 210.6	13 663,2	8 599,6

Цахилгаан эрчим хүчний хэрэглээний 21,0 хувийг Дорнод аймгийн аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх, 13,0 хувийг Сүхбаатар аймаг, 66,0 хувийг уул уурхай, ашигт малтмал, газрын тосны аж ахуйн нэгжүүд эзэлж байна. Эрчим хүчний томоохон хэрэглэгч болох Тамсагийн тосны орд газрын ХХI талбай ашиглалтанд орж, "Шинь Шинь" ХХК-ийн үйл ажиллагаа сэргэн цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэн нь ашигтай ажилласан гол шалтгаан болсон байна.

Хүснэгт №6 ЦЭХ-ний хэрэглээ өссөн компаниудын судалгаа

ЦЭХ нэмж авсан компаниуд	Он	ЦЭХ-ний хэрэглээ	
		кВтц	Мөнгөн дүн
Тамсаг 19	2014	50 884 896	7 426 413 334
	2015	57 369 357	10 174 285 333
	2016	58 595 280	10 795 701 488
	17.04.30	15 333 584	4 176 339 872
Тамсаг 21	2016	42 511 050	7 832 743 535
	17.04.30	19 210 830	3 497 326 298
Шинь Шинь	2014	4 347 747	636 321 370
	2015	4 121 677,55	744 910 900
	2016	21 191 982,00	3 889 838 586
	17.04.30	11 488 996,00	2 126 411 659

Томоохон уул уурхайн компаниудын хэрэглээ өссөнөөр Сүхбаатар аймгийг 2015 оны 12 дугаар сараас эхлэн, Төмөртийн уурхайг 2016 оны 7 дугаар сараас эхлэн "ЦДҮС" ТӨХК-аар хангуулж эхэлсэн байна.

Импортоор 2016 онд БНХАУ-аас Дорнод аймгийн Хэрлэн сумын Хавирга боомт, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум 2,267.7 мян.кВтц, ОХУ-аас Дорнод аймгийн Баян-Уул сумын Ульхан майхан боомт 142.7 мян.кВтц нийт 2,410.3 мян.кВтц цахилгаан эрчим хүч импортоор худалдан авч 305,2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. 2016 онд импортын цахилгаан эрчим хүчинд 740.6 сая төгрөгийн алдагдал хүлээж ажилласан байна. Чулуунхороот, Халхгол сумдыг дотоод эх үүсвэрээр хангах болсноор өмнөх онтой харьцуулахад импортын хэрэглээ 43,4 хувиар буурчээ.

Хүснэгт №7 "ЦЭХ-ний судалгаа"

№	Үзүүлэлт	х/нэгж	2015 гүйц	2016 төл	2016 гүйц	2015 оны гүйцэтгэлээс	2016 оны төлөвлөгөөнөөс
1	Өөрийн түгээлт	мян.кВтц	155,541.8	150,230.0	182,847.9	27,300.1	32,617.9
2	ЦДҮС-ТӨХК иас ХАЦЭХ	мян.кВтц	4,096.4	28,930.0	39,264.6	35,168.2	10,334.6
3	Импортоор ХАЦЭХ	мян.кВтц	4,262.5	1,381.3	2,410.4	-1,852.4	-823.6
	Нийт түгээлт	мян.кВтц	163,900.7	180,541.3	224,522.9	60,622.2	43,981.6

Нийт 1646,5 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлоготой ажилласаныг судалж дүгнэхэд Сүхбаатар салбарын барилга угсралтын гэрээт засварын ажлын орлого хамгийн өндөр буюу 169,7 хувийн өсөлт нөлөөлсөн байна.

Хүснэгт №8 "Үйл ажиллагааны бус орлого" /сая төгрөг/

№	Үйл ажиллагааны бус орлогын задаргаа	2016 төл	2016 гүйц
1	Кислород борлуулсаны орлого	17 400,00	13 079,60
2	Телевизийн хураамжийн орлого 20 хувь	36 000,00	23 584,97
3	Барилга угсралт гэрээ засвар ажлын орлого	48 300,00	46 160,73
4	Төлбөрт үйлчилгээний орлого	9 600,00	13 210,39
5	Тендерийн материал	2 600,00	3 545,45
6	Хогны хураамжийн орлого /30 хувь/	33 600,00	36 520,85
7	Хүү торгууль алдангийн орлого	51 927,80	70 093,30
8	Туслах аж ахуйн орлого	32 564,60	44 348,10
9	Түрээсийн орлого	33 027,80	49 310,90
10	Техникийн нөхцөл олголт	36 000,00	9 509,60
11	Гадаад валютын ханшнийн өөрчлөлтийн бодит ашиг	-	176 271,30
12	Гадаад валютын ханшнийн өөрчлөлтийн бодит бус ашиг	40 000,00	66 496,20
13	Хойшлогдсон орлого	-	147 461,53
14	Мессеж мэдэгдэл	9 600,00	9 547,94
15	Бусад бараа материалын орлого	-	35 965,17
16	Сүхбаатар салбарын бусад орлого	515 860,00	901 464,35
	- Барилга угсралт гэрээ засвар ажлын орлого	483 000,00	820 041,17
	- Алданги баримтын орлого	6 600,00	5 496,82
	- Техникийн нөхцөл олголт	540,00	1 227,64
	- Төлбөрт үйлчилгээний орлого	3 840,00	7 886,52
	- ТВ-ийн хураамжийн орлого 15%	10 440,00	11 411,59
	- Хүүгийн орлого	600,00	2 043,17
	- Тоолуур баталгаажуулалтын төлбөр	-	1 550,82
	- Материал борлуулсаны орлого	-	1 057,27
	- Газардуулгын эсэргүүцэл хэмжсэн төлбөр	4 640,00	1 861,82
	- Төмөртэйн сургалтын төлбөр	800,00	765,00
	- ҮХөрөнгө борлуулсаны орлого	5 400,00	6 909,09
	- Хойшлогдсон орлого	-	41 213,45
	Нийт дүн	866 480,20	1 646 570,38

2.2. Үйл ажиллагааны орлого нэмэгдэхийн хэрээр арвилан хэмнэлтгүй ажилласан байна.

"ДБЭХС" ТӨХК нь 2016 онд нийт 35,5 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж үндсэн үйл ажиллагаанд 32,9 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн бус ажиллагаанд 2,6 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ.

Нийт зардлын 21,7 %-ийг түлшний зардал, 11,7%-ийг үндсэн хөрөнгийн элэгдэл, 31,6 %-ийг цалингийн зардал, 5,5 %-ийг шатахуун, урсгал зардал, 16,2 %-ийг худалдан авсан цахилгаан эрчим хүчний өртөг, 10,5%-ийг бусад тогтмол зардлууд, 2.8%-ийг ажилчдын нийгмийн зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт №9 "Зардлын судалгаа"

Зардлын төрөл /сая төгрөг/	2016 он		Зөрүү	эзлэх %
	Төл	гүйц		
Түлшний зардал	6,858.1	7,689.7	831.60	21.7%
Худалдаж авсан цахилгааны өртөг	4,011.6	5,765.4	1,753.80	16.2%
Шатахуун	564.7	492.1	(72.60)	1.4%
Урсгал зардал, сэлбэг материал	1,231.4	1,455.0	223.60	4.1%
Үндсэн ба нэмэгдэл цалин НДШ	10,059.8	11,227.2	1,167.40	31.6%
Үндсэн хөрөнгийн элэгдэл	4,001.8	4,135.0	133.20	11.7%
Ажилчдын нийгмийн зардал	891.2	1,005.7	114.50	2.8%
Бусад тогтмол зардлууд	1,904.8	2,157.8	253.00	6.1%

Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн	29,523.4	33,927.9	4,404.50	95.6%
Үйл ажиллагааны бус зардал	265.2	1,562.5	1,297.30	4.4%
Нийт зардал	29,788.6	35,490.4	5,701.80	100.0%

Түлшний зардлын 97,1 хувь буюу 7470,0 сая төгрөг нь нүүрсний зардал, 2.9 хувь буюу 219,7 сая төгрөгийг мазутын зардал эзэлж байна.

Худалдаж авсан цахилгааны өртөг нь Сүхбаатар аймаг, Төмөртийн уурхайг ЦДҮС ТӨХК-аас ЦЭХ худалдан авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Урсгал зардал, сэлбэг материалын өсөлт нь хэрэглээ өссөнтэй холбоотой урсгал засвар 40,7 сая, цехүүд 182,6 сая төгрөг байна.

2016 онд нийт 602 орон тоотой ажиллахаас дунджаар 615 орон тоотой / Дорнод салбарт 8, жирэмсний амралттай 5,/ ажиллаж цалингийн зардалд нийт 9,939.1 сая төгрөг зарцуулж, төлөвлөснөөс 1,079.5 сая төгрөгөөр хэтэрсэн.

- Жилийн үр дүнгийн шагнал 852,3 сая төгрөг
- Үндсэн цалин 50,1 сая төгрөг
- Илүү цаг 129,7 сая төгрөг
- Сарын үр дүнгийн шагнал 47,3 сая төгрөг

Ажилчдын нийгмийн зардалд 1005,7 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөсөн хэмжээнээс 114,5 сая төгрөгөөр хэтэрсэн нь зарим төлөвлөгдөөгүй зардлууд гарсантай холбоотой байна. Үүнээс тэтгэмжид

- Ажлаас чөлөөгдсөн тэтгэмж – 22,4 сая төгрөг
- Хүндэтгэх шалтгааны улмаас төлөвлөснөөс илүү 3 хүнд өндөр насны тэтгэвэрт гарсны тэтгэмж - 40,1 сая төгрөг
- ДШС цехийн ажилтан 2015 оны 12 сард тэтгэвэрт гарсан боловч оны дараа тэтгэмж авсан - 21,5 сая төгрөг

Батлагдсан төлөвлөгөөнөөс хэтэрсэн гүйцэтгэлтэй зардлууд гарсан байна. Монгол улсын хэмжээнд хэмнэлтийн горимд шилжин ЗГ-ын 2015 оны 147, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолыг баримталж ажиллаж байхад “ДБЭХС” ТӨХК нь буцалтгүй тусламж, шагнал урамшуулал, урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээ зэрэг хэмнэж болох зардлуудыг батлагдсан зорилтот түвшнээс нийт 20,3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт №10 “Ажилчдын нийгмийн зардлын задаргаа” /Мян.төг/

№	Зардлын төрөл	2016 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ажиллагсадын хоолны хөнгөлөлт	373,485.0	377,029.4	3544,4
2	Ажиллагсадын түлшний хөнгөлөлт	11,788.5	14,664.9	2876,4
3	Ажиллагсдад олгосон тусламж, буцалтгүй тусламж	13,158.2	19,950.0	6791.8
4	Тэтгэмж	128,716.8	212,596.2	83879,4
5	Нөхөн төлбөрийн зардал	-	2,000.0	2000,0
6	Эрүүл мэндийн үзлэг, эмчилгээ, сувилгааны зардал	2,214.0	6,053.5	3839,5
7	Ажиллагсдад олгосон шагнал урамшуулал	27,800.0	39,232.2	11432,2
8	Болзолт уралдаан	25,360.0	25,423.6	63,2
9	Урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээний зардал	1,700.0	3,806.2	2106,2
10	Баяр ёслолын арга хэмжээний зардал	37,000.0	34,983.1	-2016,9
11	Орон сууцны хөнгөлөлт	270,000.0	270,000.0	-
ДҮН		891,222.5	1,005,739.1	114516,6

Үйл ажиллагааны бус зардал

Үйл ажиллагааны бус зардал мөн адил батлагдсан зорилтот түвшнээс хэтэрч 265,2 сая төгрөгөөр батлагдсан байхад 1581,7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Төлөвлөгөөнд тусгагдаагүй төлөвлөх боломжгүйд гадаад валютийн ханшийн өөрчлөлтийн бодит бус алдагдал, Сүхбаатар салбарын барилга угсралт, гэрээ, засварын гүйцэтгэл зэрэг зардлууд байна.

Төлөвлөх боломжтой Фитнес клубын засвар, шинэ жилийн арга хэмжээ, актлагдсан хөрөнгө, ДЦС-ын туршилтын лабортори, хэрэглэгчийн хохирол барагдуулалт зэрэг нийт 35,5 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй дээрх зардлуудыг гаргасан байна.

Хүснэгт №11 “Үйл ажиллагааны бус зардлын задаргаа” /Мян.төг/

№	Зардлын задаргаа	2016 он.төл	2016 он.гүйц
1	Туслах аж ахуйн зардал	11 651,3	24 841,50
2	Богино хугацаат зээлийн хүү	51 000,0	71 010,30
3	Барилга угсралт гэрээ засвар үйлчилгээ	15 000,0	40 773,18
4	Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн алд	68 100,0	437 641,70
5	Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус алдагдал / ханшийн тэгшитгэл /	-	6 612,70
6	Гэрээт оюутны сургалтын төлбөр	15 000,0	16 627,58
7	Өндөр настан ахмадын зардал / тэтгэмж /	68 700,3	62 427,70
8	Хэвлэл захиалга	500,0	1 864,50
9	Эрчим хүчний салбарын ойн хандив	-	3 000,00
10	Улаанзагалмайн гишүүний татвар	2 200,0	3 980,00
11	Фитнес клубын засвар	-	3 600,00
12	Саам сувилалын зардал	10 750,0	13 582,71
13	Шинэ жилийн арга хэмжээ	-	12 561,68
14	Актлагдсан хөрөнгө	-	13 181,80
15	Тендерийн урилга зарын үнэ	200,0	720,00
16	ДЦС-ын туршилтын лабортори	-	2 000,00
17	Хэрэглэгчийн хохирол барагдуулалт	-	1 236,50
18	Бусад	865,0	1 113,70
19	Сүхбаатар салбарын бусад зардал	21 268,0	864 981,72
	- Барилга угсралт гэрээ засвар үйлчилгээ		818 302,90
	- Өндөр настан ахмадын зардал		7 979,50
	- Автограф барих		9 581,82
	- Тоолуур тохирууллагын төлбөр		16 702,07
	- Шинэ конторын гадна тохижилт / хаяг, лого, самбар, хаалт/		5 163,80
	- Явуулын сууц		2 000,00
	- Краны магадлагаа		1 500,00
	- Бусад		3 751,63
	Нийт дүн	265 234,60	1 581 757,27

“ДБЭХС” ТӨХК нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 “ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.” гэсэн заалтыг зөрчиж 2016 болон 2017 оны 4 дүгээр сарын байдлаар


- Эрчим хүчний зохицуулах хорооны ойн хандив 3,0 сая төгрөг,
- УБЦТС-ийн 85 жилийн ойд 1,5 сая төгрөг,
- Налайхын уурхайн 40 жилийн ойд 400,0 мянган төгрөг,
- Ерөнхий боловсролын сургуулийн ойн арга хэмжээнд 4 багшийг 800,0 мянган төгрөг,
- ЭХЗХ-ны 2 мэргэжилтэнд 400,0 мянган төгрөг, нийт хандив, тусламжид 6,1 сая төгрөгийг зарцуулжээ.

ҮАГ-аас 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар ЗГ-ын 184 дүгээр тогтоолын хүрээнд ажиллах, компаний албан тушаалын болон дуудлагын авто машин хэрэглэх эрх бүхий албан тушаалын лимитийг ТУЗ-р батлуулж мөрдөж ажиллах, суудлын авто машин унах эрхгүй албан тушаалтанд шатахууны зардал олгохгүй байх гэсэн зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, ТУЗ-өөр шийдвэрлүүлээгүй, гүйцэтгэх захирал тушаал гарган доорх хүснэгт дэх албан тушаалтнуудад бинзений лимит тогтоон олгож байна.

Хүснэгт №12 "Картаар авсан бензин"

Албан тушаал	Сарын лимит /өссөн дүнгээр/ 2016 он	2016 он	2017 оны 4 сар
		Олгосон дүн	Олгосон дүн
Ерөнхий инженер	1452	2 424 840	850 080
ТСБХ-ийн дарга	1452	2 424 840	850 080
ХҮХ-ийн дарга	700	1 058 200	600 000
Дорнод салбарын дарга	1352	2 198 880	824 320
ТХА-ны дарга	330	502 200	0,0
ДХА-ны дарга	330	502 200	0,0
УБ дахь төлөөлөгч	1628	2 477 520	888 000
ХҮХ-ийн мэргэжилтэн	1100	1 674 000	748 650
ХҮХ-ийн мэргэжилтэн	900	1 276 500	600 000
Байцаагчид	5435	7 686 800	2 677 500
Дүн	14579	22 225 980	8 787 280

Дүрслэл №6 "Компаний нийт ажилчдын 30,0 хувьд явуулсан санал асуулгын дүн"



Дүрслэл №7 Дүрслэл №6 “Компаний нийт ажилчдын 30,0 хувьд явуулсан санал асуулгын дүн”

9. Төсөв, санхүүтэй холбоотой асуудлаар танд хохирч байсан тохиолдол гарсан уу?



2.3. “ДБЭХС” ТӨХК-ийн авлага 1087,0 хувиар зорилтот түвшнээс өссөн байна.

“ДБЭХС” ТӨХК 2016 онд авлага, өглөгийг зорилтот түвшинд барьж ажиллаагүй байна.

Хүснэгт №13 “Авлага, өглөгийн гүйцэтгэл” /Мян.төг/

Зардал	2015 он гүйцэтгэл	2016 оны төлөвлөгөө	2016 оны гүйцэтгэл	Зөрүү /хувь/
Авлага	1988,3	100,0	1187,0	1087,0 %
Нийт өглөг	19043.9	12000.0	11829.3	1.4%
Богино хугацаат өглөг	1412,5	800,0	1304,4	63,1%

“Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-ийн он дамжсан 804,2 сая төгрөгийн авлага УАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу үүссэн авлага бөгөөд гэрээний дагуу 2017 оны нэгдүгээр сард барагдсан байна.

Айл өрх болон байгууллага, иргэдээс авах тооцооны бусад авлагууд буурч, үйлдвэр, аж ахуйн нэгжээс авах цахилгаан эрчим хүчний борлуулалтын авлага өссөн байна.

Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөр 2016 онд 1304,4 сая төгрөг болж урьд оны мөн үетэй харьцуулахад 108,1 сая төгрөг буюу 8%-иар буурсан ч зорилтот түвшнээс 504,4 сая төгрөгөөр буюу 63,1 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Дүрслэл №8, “Богино хугацаат өглөг”



2017 оны 1 дүгээр улирлын байдлаар богино хугацаат өглөг 2004,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 700,4 сая төгрөгөөр илүү өссөн байна. Энэ өсөлтөд Петро чайна дачин тамсаг ХХК-ийн байршуулсан 1,5 тэрбум төгрөгийн барьцаа нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөр

ХБНГУ-ын Сэргээн босголтын банкны “Станц шинэчлэл I, II ” төсөл, Дэлхийн банкны “Эрчим хүчний алдагдал бууруулах” төслийн урт хугацаат дамжуулан зээлдэх гэрээг 2012 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Сангийн яамтай шинэчлэн байгуулж, зээлийн дүн, төлбөрийг хуваарийн дагуу нийт 2120,3 сая төгрөг төлсөн. Зээлийн нийт үлдэгдэл 10,5 тэрбум төгрөг байна.

III. Бүлэг: Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

3.1. Төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна.

“ДБЭХС” ТӨХК нь жил бүрийн үйл ажиллагаандаа худалдан авах бараа, ажил үйлчилгээг төлөвлөж, ТУЗ-ийн хуралд оруулж, ТӨХ-оор баталсан жилийн зорилтот түвшингийн үзүүлэлтэд тусгадаг байна.

“ДБЭХС” ТӨХК нь 2016 онд хөрөнгө оруулалтын 40 нэр төрлийн 1,7 тэрбум, их засварын 22 нэр төрлийн 3,7 тэрбум, ТЗБАХ-ний 14 нэр төрлийн 1,0 тэрбум, барилга байгууламжийн 3 нэр төрлийн 0,1 тэрбум, урсгал зардлын 19 нэр төрлийн 1,9 тэрбум, нийт 98 нэр төрлийн 8,4 тэрбум төгрөгийн ажлыг төлөвлөж батлуулсан байна.

2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 16 нэр төрлийн 1,5 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг төсвийн тодотголоор нэмж батлуулсан байна.

Хүснэгт №14. "Ашигласан худалдан авалтын арга" /тэрбум.төг/

Он	Нийт төсөл арга хэмжээ		НТШ		Харьцуулалтын арга		Шууд гэрээ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2016	98	8,4	19	6,0	70	2,3	9	0,1
2017	89	7,5	20	5,6	56	1,8	13	0,1

2017 онд нийт 8,2 тэрбум төгрөгийн төсөв бүхий 99 багц хөрөнгө оруулалтын худалдан авах арга хэмжээг зохион байгуулж ажиллахаар төлөвлөн батуулсан байна.

2017 оны 05 дугаар сарын 01-ний байдлаар НТШ-аар 20 нэр төрлийн, харьцуулалтын аргаар 56 нэр төрлийн, шууд худалдан авалтаар 13 нэр төрлийн тус тус хөрөнгө оруулалтын багц төсөл арга хэмжээний дагуу худалдан авалтуудыг зохион байгуулж гүйцэтгэл 89,9 хувьтай байна.

"ДБЭХС" ТӨХК-ийн бараа, ажил үйлчилгээ худалдан авалтад орон нутгаас 2016 онд нийт шалгаруулалтын 40,8 хувь буюу 40 ААН, 2017 оны 05 дугаар сарын 01-ний байдлаар нийт шалгаруулалтын 50,6 хувь буюу 45 ААН шалгарсан байна.

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 48.5-д заасны дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг байгууллагын вэб хуудас, www.ub-procurement.mn болон www.tender.gov.mn, өдөр тутмын "Монголын үнэн" сонинд нийтэлсэн байна.

Худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэхийг аудитын явцад баримт бүрээр тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2016 оны төлөвлөгөөнд тусгаагүй 321,7 сая төгрөгийн дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. *Хүснэгт:15*

№	Төсөл төсөл, хэмжээ	Төсөвт өртөг /сая.төг/	Гүйцэтгэсэн байгууллага
1	Галын тоосго	26,1	"Насос ремонт монтаж" ХХК
2	Багаж нийлүүлэх	33,5	"ДОРНЫН СҮРВЭЙ"
3	Урсгал засварт шаардлагатай материал	17,5	"НАРАН ТҮҮЧЭЭ" ХХК
4	Тэлүүр хаалт	13,1	"ЭРДЭНИЙН АЛТАН СОЁМБО" ХХК
5	Турбины голын нягтруулагч	22,5	"НАСОС РЕМОНТ МОНТАЖ" ХХК
6	Өндөр даралтын хаалт	18,5	"ЭРХЭТ ЦЭЛМЭГ ИНЖЕНЕРИНГ" ХХК
7	Усны хаалт	12,5	"ЯЛГУУН СОНДОР" ХХК
8	Автомат таслуур	34,2	"ГАН ТЕСЛА" ХХК
9	Компанийн ажиллагсдыг багц үзлэг шинжилгээнд хамруулах	10,4	"БОЭТ"
10	Зураг төсөл боловсруулах	17,1	"ГЭРЭЛ ТӨСӨЛ"
11	Сургалтын танхим засварлах	9,7	"ЦАХИМ ХИЙЦ" ХХК
12	Ажиллагсдыг аялуулах	14,3	"ДААДАР ТУРС" ХХК
13	Зураг төсөл боловсруулах	23,0	"ХОС ҮРЖИН" ХХК
14	Агуулахын засвар	9,5	"ЦАХИМ ХИЙЦ" ХХК
15	Зураг төсөл боловсруулах	49,9	"ГЭРЭЛ ТӨСӨЛ" ХХК
16	Харуулын өрөөний засвар	9,9	"БАТ ЭНХ ҮҮД" ХХК

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.1.1 дэх “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 8.1.2 дахь “шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” гэсэн заалтуудыг зөрчиж 2016 онд бараа, түүхий эд материал худалдан авсан байна. Тухайлбал,

- “Золмөрөн” ХХК 61,0 сая төгрөгийн автын сэлбэг
- “Гүнгэрваа” ХХК 15,7 сая төгрөгийн ЦДАШ-ын сэлбэг
- “ТОД-ЭКСИМ” ХХК 26,2 сая төгрөгийн ЦДАШ-ын сэлбэг
- “ХОС ҮРЖИН” ХХК 23,0 сая төгрөгийн зураг төсөл боловсруулах

Мөн 23,0 сая төгрөгийн зураг төсөл боловсруулах ажилд “ХОС ҮРЖИН” ХХК шалгарсан нь зураг, төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эсэх нь тодорхойгүй, баримтанд байхгүй.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил мэргэжлийн байгууллагын эрхийн хугацаа дууссан “АНУ СӨРВЭЙ” ХХК-ийг тендерт шалгаруулсан байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5 дахь “хамаарал бүхий этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг, 8.1 дэх “Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэж заасныг зөрчин “Авьаа” ХХК-ийн захирал М.Болдбаатарын хадам ах болох Хангамж үйлчилгээний хэлтсийн инженер Д.Ганбаатар нь худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцсон байна.

“Авьаа” ХХК нь 2016 онд 4 удаагийн 160,3 сая төгрөгийн, 2017 онд 2 удаагийн 77,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаанд оролцон шалгарсан байна.

Үнэлгээний хороонд тухайн ажлыг хариуцсан мэргэжилтэн, ИТХ-аас томилсон иргэн, аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн зэргийг оролцуулан, нийт үнэлгээний хороог 5-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажилласан боловч ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.1-т “...хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч,...оролцуулна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Мөн аймгийн ЗДТГ-ын даргын зөвшөөрлөөр мэргэжилтэнг үнэлгээний хороонд оруулж байх шаардлагатай байна.

Худалдан авах ажиллагаатай холбоотой санал, гомдол иргэд, аж ахуйн нэгжээс ирээгүй байна.

Дүрслэл №9, “Ажилтнуудаас авсан санал асуулгын дүн”



Санал асуулгад 166 ажиллагсад хамрагдав.

3.2. Гэрээнд заагдсан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй гүйцэтгэгчид ногдуулах алдангийг тооцоогүй байна.

“ДБЭХС” ТӨХК нь 2016 онд Төрийн өмчийн хорооноос баталсан төлөвлөгөөт 98 нэр төрлийн 8,4 тэрбум төгрөгийн худалдан авалтыг хийж гүйцэтгэхээс 97 нэр төрлийн худалдан авалтад 7,9 тэрбум төгрөгийг зарцуулж 0,5 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Төлөвлөгөөт хөрөнгө оруулалтаас “МЗЭ” ХХК-ийн гүний худгийн насос /SP-160/ нийлүүлэх ажил нь тухайн компаниас шалтгаалж гэрээт хугацаандаа хэрэгжээгүй он дамжиж хийгдсэн байна. Гэрээг дүгнэж 2017 онд 6,2 сая төгрөгийн алданги тооцсон байна.

2016 онд төсөвт өртгөөс хэтэрсэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулан дараах ажлууд хийгдсэн байна.

Хүснэгт №16. /сая.төг/

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэтрэлт	
				Зөрүү дүн	Хувиар
1	ПЭН 5-ийн хөдөлгүүр	40,0	49,5	9,5	23,7
2	Баруун-Урт сумын төв 1 фидерийн 10 кВ-ын ЦДАШ 3.8 км АС-50 дамжуулагчийг АС-70 болгох	13,1	14,9	1,8	13,7
3	Барилгын материал	30,0	33,3	3,3	11,0
4	Гэрэлтүүлэг	24,0	26,5	2,5	10,4

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.1-д “дараах тохиолдолд захиалагч бүх тендерээс татгалзана”, 30.1.3-т “шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн”, 46 дугаар зүйлийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Мөн 2016 онд автомашин худалдан авах ажиллагаанд “МИСУСКАЙ” ХХК 38600,0 \НӨАТ ороогүй\ мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч гэрээ байгуулсан боловч санхүүжилтийг олгохдоо 42460,0 \НӨАТ орсон\ мянган төгрөгөөр буюу 3860,0 мянган төгрөгөөр илүү шилжүүлж үр ашиггүй ажилласан байна.

Худалдах, худалдан авах гэрээнд заагдсан хугацааг хэтрүүлсэн ажилд 2016 онд алдангийг суутган тооцоогүй нийт 38,0 сая төгрөгийн 7 ажил байна. Үүнд:

- “Золмөрөн” ХХК-ийн гүйцэтгэсэн автын сэлбэг нийлүүлэх ажил 27 хоногоор хугацаа хэтэрсэнд 2,7 сая төгрөгийн алданги,
- “Дорнын Буян-Эрдэнэ” ХХК-ийн гүйцэтгэсэн гинжний бэлдэц нийлүүлэх ажил 37 хоногоор хугацаа хэтэрсэнд 3,6 сая төгрөгийн алданги,
- “Хүй голомт” ХХК-ийн гүйцэтгэсэн хэрэглээний төмөр нийлүүлэх ажил 36 хоногоор хугацаа хэтэрсэнд 2,5 сая төгрөгийн алданги,
- “Авьаа” ХХК-ийн гүйцэтгэсэн бараа материал нийлүүлэх 4 ажил нийт 438 хоногоор хугацаа хэтэрсэнд 29,2 сая төгрөгийн алданги.

Аудитын явцад тус компанид дээрх байгууллагуудаас гэрээний хугацааг хойшлуулж өгөх хүсэлт хүргүүлсэн албан тоотыг ирүүлсэн боловч гэрээг сунгасан гэж батлах хурлын тэмдэглэл болон бусад нотлох баримт байхгүй байна.

УАЗ Фермер 39034 маркийн автомашин, ГАЗ-3221 маркийн микро автобус нийлүүлэх үнийн санал ирүүлж гэрээ байгуулсан боловч гэрээгээ зөрчиж өөр маркийн автомашин, микро автобус нийлүүлсэн, мөн техникийн тодорхойлолт байгаа гэх боловч үзүүлэх баримт байхгүй байгаа нь захиалагч талаас хяналт муу байгааг харуулж байна.

Дээрх дүгнэлтээс үзэхэд ХАА-ны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих дотоодын хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Дүрслэл №10. “Ажилтнуудаас авсан санал асуулгын дүн”

Санал асуулгад 166 ажиллагсад хамрагдав.



IV. Бүлэг: Дотоод хяналтын алба нь хяналтын зарим чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.1. Хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

“Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 6.4⁹ -д заасныг үндэслэн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 19 тоот тогтоолоор дотоод хяналтын албыг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр дотоод хяналтын албаны хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталсан байна. ҮАГ, аймгийн МХГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу дотоод хяналтын албыг байгуулж, 2016 оноос хойш хяналт шалгалтын чиглэлээр төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаа нь эрчимжиж байна.

Хөндлөнгийн хяналтаар ЭХЯ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, аймгийн МХГ, Татварын ерөнхий газрын харьяа Улсын төсвийн орлого, хяналтын газар техник, аюулгүй ажиллагаа, санхүү, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаанд хяналт тавьж байна. Санхүүгийн тайланг ҮАГ-ын гэрээт аудитын компани болох “Нью Эстимейтор” ХХК, төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлыг ЭХЯ, Төрийн бодлого зохицуулалтын газар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг аймгийн МХГ-ууд тус тус хяналт шалгалтыг зохион байгуулж байгаа нь үр нөлөөтэй тогтолцоо бүрдсэнийг харуулж байна.

4.2. Дотоод хяналтын алба нь хяналтын зарим чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын “Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, “ДБЭХС” ТӨХК-ийн захирлын 2016.01.04-ний өдрийн “Дотоод хяналтын албаны хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Дотоод хяналтын албаны дарга Н.Баасанпүрэв, Дотоод хяналтын ажилтан У.Энхчимэг (2016-2017 оны 04 дүгээр сар хүртэл ДХА-ны ажилтнаар Д.Мөнхбаяр ажиллаж байжээ.) нар томилогдон ажиллаж байна.

“ДБЭХС” ТӨХК-ийн дотоод хяналтын албаны хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын дагуу, дотоод хяналтын алба нь 2016, 2017 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж ажилласан байна.

Гэвч “ДБЭХС” ТӨХК-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр нөлөө багатай, төлөвлөгөөг бодитой төлөвлөхгүй байна гэж үзэж байна. Үүнд:

2016 онд нийт 20 ажил хийхээр төлөвлөж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- ДЭХ-ний балансжилт, түгээлтийн болон зүй бус алдагдал тодорхойлох, ашиглалтын түвшин, орлого төвлөрүүлэлтэд шалгалт хийх
- Харуул хамгаалалтын албаны үйл ажиллагаа, ажилчдын цагийн бүртгэл
- Шинээр ашиглалтад орсон ШТС-д шалгалт хийх
- GPS төхөөрөмжөөр бульдозерын түлш зарцуулалтад хяналтыг сайжруулах
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
- Хууль журмын хэрэгжилт
- 2016 оны хагас жилийн санхүүгийн тайланд дотоод аудит хийх
- Сүхбаатар салбарын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх
- Үйлдвэрчний эвлэлийн хороонд хийх шалгалт
- Мөнгөн гүйлгээний урсгал

⁹ 6.4.Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг Засгийн газар тогтооно.

- Захирлын тушаал хэрэгжилт
- Цех, алба, хэлтсийн ажлын төлөвлөгөө, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, өвлийн бэлтгэл
- Тооллогын явц, бараа материалын үлдэгдэлд тавих хяналт
- Хөдөлмөр хамгааллын III шатны үзлэгт тавих хяналт зэрэг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажлуудыг зохион байгуулж ажиллажээ.

Дотоод аудитын албаны 2016 оны хийх ажлын төлөвлөгөөнөөс МУ-ын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах, 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдөр ЗГ-ын 2015 оны 336-р тогтоолын хэрэгжилт, Компанийн орон тооны бус комисс, зөвлөлүүдийн тайланг авах, анализ хийж зөрчил дутагдлыг илрүүлэх зэрэг төлөвлөгөөт ажлууд хэрэгжээгүй байна.

2017 онд нийт 16 ажил хийхээр төлөвлөж, хэрэгжих шатандаа явж байна.

Дотоод хяналтын алба нь зөрчил дутагдлыг илрүүлж, засаж залруулах зөвлөмж өгч ажилласны үр дүнд 2012-2014 онд 13, 2015 онд 29, 2016 онд 76 зөрчлийг илрүүлж ажилласан ч журмын хүрээнд зарим хэлтэс, албадын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Өөрөөр хэлбэл дотоод хяналтын алба нь жилийн ажлын төлөвлөгөөг батлуулахдаа "ДБЭХС" ТӨХК-ийн дотоод хяналтын албаны хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 5 дахь зүйлд заасан үйл ажиллагааны зарим заалтыг орхигдуулж байна. Тухайлбал: Захиргаа удирдлагын хэлтэс, төлөвлөлтийн хэсэг, хангамж, үйлчилгээний хэлтэс, инженерийн алба, түлш дамжуулах цех, зуухан цех, автогражийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг орхигдуулсан байна.

Хөндлөнгийн хяналт, шалгалтын байгууллагуудаас 2016-2017 онд хийсэн хяналт шалгалтаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

- Техник, аюулгүй ажиллагаатай холбоотой аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хийгдсэн хяналт шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгавар, албан шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор ТХА-наас холбогдох цех, тасгуудад албан даалгавар өгч тухай бүрт нь хариу авч, хэрэгжилтийг ханган ажиллажээ. Албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах, цех, тасгуудын аюулгүй ажиллагааг хангах зорилгоор 2016 онд нийт 14 удаагийн албан шаардлагыг цех, тасгийн удирдлагуудад өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.
- Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын хэлтсийн төлөвлөгөөт шалгалтаар 2016 онд 65,4 сая төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги, хүүгийн төлбөрийн акт тогтоогдож, тухайн онд төлбөрийн актыг барагдуулж ажиллажээ.
- УАГ-ын Санхүүгийн аудитын газраас "ДБЭХС" ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийгдэж, төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаанд 5 зөвлөмж өгөгдөж, зөвлөмжийн мөрөөр ажлын төлөвлөгөө боловсруулж, ажилласан байна. Аудитаар санхүү, дотоод аудитын чиглэлээр мэргэшсэн хүнийг ажиллуулах гэсэн зөвлөмжийн дагуу 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс дотоод хяналтын албаны ажилтныг сэлгэн аудиторын батламжтай, мэргэшсэн нягтлан бодогчийг ажиллуулж эхэлсэн байна.

Дотоод аудитын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаагүй, журамд зааснаар ажлаа төлөвлөөгүй байгаа шалтгаан нь дотоод хяналтын ажилтанд мэргэжлийн бус, энэ чиглэлээр мэргэшээгүй хүн ажиллан дотоод хяналтын

албаны хийх ажлын төлөвлөгөөг дутуу боловсруулж, хэрэгжүүлсэнтэй холбоотой байна. Мөн компанийн хэмжээнд 2 албан хаагч дотоод хяналтын ажлыг хэрэгжүүлж байгаа нь ажлын ачаалал, чиг үүрэг их байгаатай холбоотой байна.

Иймээс цаашид албаны төлөвлөгөөг “ДБЭХС” ТӨХК-ийн дотоод хяналтын албаны хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 5.1.1-5.1.15-д заасны дагуу дэлгэрэнгүй боловсруулж, хэрэгжүүлж ажиллах, орон тоог нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. “ДБЭХС” ТӨХК-ийн 2016 оны зорилтот түвшин биелсэн ч үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн бүтээмж, чанарын удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.
2. Зарим цех, хэлтэс, албанд /турбин, зуух, түлш дамжуулах цех/ орон тоо дутагдалтай байна. “ДБЭХС” ТӨХК-ийн түвшинд 602 хүнд 1 хүний нөөцийн менежер, 2 дотоод хяналтын ажилтан байгаа нь ажлын ачаалалд нөлөөлж байна.
3. Ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлахдаа ил тод, нээлттэй зарлахгүй, ажилтан, удирдах ажилтан сонгон шалгаруулж авахдаа “Боловсон хүчний нөөцийг судалж бүрдүүлэх, ажилд авах хүнийг сонгон шалгаруулах журам”, ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг мөрдөхгүй байна. Мэргэжлийн бус, мэргэжил эзэмшээгүй иргэдийг ажиллуулж байна.
4. “ДБЭХС” ТӨХК-ийн ажлын байрны тодорхойлолт нь агуулга, бүтцийн хувьд стандартад нийцээгүй, “Боловсон хүчний нөөцийг судалж бүрдүүлэх, ажилд авах хүнийг сонгон шалгаруулах журам”-ын 3.3-ын “б” дахь заалт нь утга агуулгын хувьд алдаатай байна.
5. Ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу байна.
6. “ДБЭХС” ТӨХК нь 2016 оноос эхлэн улсын төсвөөс татаас авалгүйгээр ашигтай ажиллаж 316,0 сая төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлээд байна.
7. ҮАГ-аас 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
8. Эрчим хүчний салбар болон бусад салбарт хандив, урамшуулалд 6,1 сая төгрөгийг зарцуулсан байна.
9. Авлага 1087,0 хувиар зорилтот түвшнээс өссөн байна.
10. “ДБЭХС” ТӨХК-ийн үйл ажиллагааны нийт зардал 5,7 тэрбум төгрөгөөр хэтэрсэн байна.
11. Төлөвлөгөөнд тусгагдаагүй 321,7 сая төгрөгийн 16 бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна.
12. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.1.1, 8.1.2 дахь заалтуудыг зөрчиж 125,9 сая төгрөгийн 4 бараа, түүхий эд материал худалдан авсан байна.
13. 2016 онд төсөвт өртгөөс 17,1 сая төгрөгөөр хэтэрсэн 4 худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулсан байна.
14. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шаардлага хангаагүй ажилтанг худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад оруулан ажиллуулж байна.
15. Худалдах, худалдан авах гэрээнд заагдсан хугацааг хэтрүүлсэн ажилд 2016 онд алдангийг суутган тооцоогүй нийт 38,0 сая төгрөгийн 7 ажил байна

16. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.
17. Дотоод хяналтын алба нь жилийн ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэхдээ журмын зарим заалтыг орхигдуулж байна. /Тухайлбал: Захиргаа удирдлагын хэлтэс, төлөвлөлтийн хэсэг, хангамж, үйлчилгээний хэлтэс, инженерийн алба, түлш дамжуулах цех, зуухан цех, автогражийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг орхигдуулсан./

Аудитаар нийт 595,6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 38,0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 6,1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тавигдаж, 551,5 сая төгрөгийн зөрчилд 16 зөвлөмж өгч ажиллалаа.



“ДБЭХС” ТӨХК-иас ирүүлсэн тайлбарт өгсөн Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар:

Тайлангийн төсөлд тусгагдсан 6,1 сая төгрөгийн төлбөрийн актын талаар танайхаас ирүүлсэн тайлбарыг судалж үзэхэд Төсвийн тухай хуулийн хориглосон заалттай зөрчилдөж байгаа тул төлбөрийн актыг хэвээр үлдээхээр шийдвэрлэв.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “ДБЭХС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт зөвлөж байна.

1. Бүтээмж, чанарын удирдлагын ISO 9001:2008, 2010 стандартуудыг нэвтрүүлж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.
2. Бүтэц, орон тооны зохистой түвшингийн талаар мэргэжлийн байгууллагуудын /Монголын хүний нөөцийн институт, Удирдлагын академи гэх мэт/ судалгаа, шинжилгээ хийлгэж, хүний нөөцийн бодлогын баримт бичигтэй болох, зарим шаардлагатай орон тоог нэмэгдүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах.
3. Ажлын байрны тодорхойлолт, сонгон шалгаруулах журамд заасан шалгууруудыг хангасан ажилтанг авч томилон ажиллуулах.
4. Ажлын байрны тодорхойлолтыг Монголын хүний нөөцийн институтээс гаргасан ажлын байрны тодорхойлолт боловсруулах зөвлөмж, МУ-ын Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34-р тогтоол “Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар, загвар”-ын дагуу боловсруулж, батлуулах, сонгон шалгаруулах журмыг шинэчлэн найруулах.
5. Төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан 2004 оны 18 дугаар тогтоолын дагуу¹⁰ ажилтнуудын хувийн хэргийг хөтлөх.
6. Төсвийн тухай хуулийг зөрчин хандив, тусламжаар олгосон 6,1 сая төгрөгийг төлбөрийн актаар төсөвт төвлөрүүлэх.
7. Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын хүрээнд ажиллах, ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлэх, албан тушаалын авто машин унах эрхгүй ажилтанд шатахууны зардал олгохгүй байх.
8. Үйл ажиллагааны орлого, татаасыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байх.
9. Авлага, богино хугацаат өглөгийг зорилтот түвшинд багтаан ажиллах.
10. Тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээг бодитой, үр ашигтай төлөвлөж байх.
11. Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмыг баримтлан худалдан авах аргын сонголтыг оновчтой сонгож хэрэгжүүлж байх.
12. “Үнэлгээний хороо”-ны гишүүдийг хуульд нийцүүлэн байгуулах, худалдан авах ажиллагаа ил тод шударга явагдах нөхцөлийг хангах.
13. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.
14. Гэрээний биелэлтийг хангуулж, гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй гүйцэтгэгч нарт захиалагчийн зүгээс алданги тооцож байх.
15. Гэрээний дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилт, явцад тавьж буй хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх.
16. Дотоод хяналтын албаны хяналт, шалгалтыг зохион байгуулах журмын 5.1.1-5.1.15-д заасны дагуу үйл ажиллагааны төлөвлөгөөг дэлгэрэнгүй боловсруулж, хэрэгжүүлж ажиллах.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2017 оны 07 дугаар сарын 30-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

¹⁰ Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18-р тогтоол: “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”



[illegible][illegible]


**ДӨРНОГ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГЭРҮЭЛ ДАРГА
БООГОМД ТЭГТҮҮЛЭХ АУДИТЫН
ТУШАА**

2019 он _____ № _____
_____ /_____/

Гүйцэтгэлийн аудитын тайлан
Баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуульд 13.3 дая заахт, Монгол Улсын Ерөнхий
аудитор 2014 оны 121 дүгээр тушаалаар 5 дахь заахт, 2016 оны А/00 тоот
тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заахт, аймгийн
Аудитын газрын үйлдвэрлэлийн зөвлөлөөн 2017 оны 06 дугаар зарын 23-ний өдөр
хурлын шийдвэрээр үндсэндээ ГТШААХ ю.

1. Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Тоглууцаах аудиторын
баталсан тайлагнагаах мөнгөтэйрэн дутуу "ТБХКС" ТӨХК-ийн бүтэц зохион-
байгуулалт, үйл ажиллагааны нь дотоод нэгжүүдийн гүйцэтгэлийн аудитын тайланг
батлуусгах

2. Аудитар олон нэг, айбан шавьдрайг хамраахаар батлаасгүй

3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга П.Ханданзориг, "ТБХКС" ТӨХК-ийн
гүйцэтгэл засвар Г.Очиновбаатар нарт хүргүүлсүхий

4. Гүйцэтгэлийн аудитар олон нэг, айбан шавьдратай зохиомлооныхой хэрэгсэлтэд
авчирт тэмдэг авчирхайн алхан аудитор Б.Датваамааг дайлаасгүй

ДАРГА
ТЭГТҮҮЛЭХ АУДИТ

Б.БОГОРТУУЛ



Датум, Төрийн захирлын 2017 оны 06 дугаар
сайн 28 тоо бичигийн тус тус үйлчилгээ хангагч

Төрийн захирлын үйлчилгээ

2017.06.23

№	Байгууллагын нэр	Үйлчилгээний нэвтрүүлэг/дугаар	Төрийн захирлын үйлчилгээний нэвтрүүлэг/дугаар	Мөнгөн дүн
1	ДЭДХСГ ТӨХК	ДХР Г/А/2017/01/А	Хяналт, үнэмлэхүйц хатуулах	8 100 000.0
Нийт дүн				8 100 000.0

Анхны шалгууртай хяналт

2017.06.23

№	Байгууллагын нэр	Үйлчилгээний нэвтрүүлэг/дугаар	Анхны шалгууртай хяналт нэвтрүүлэг/дугаар	Мөнгөн дүн
1	ДЭДХСГ ТӨХК	ДХР Г/А/2017/01/А	Зардал илгээлтийн тухай	35.0
2	ДЭДХСГ ТӨХК	ДХР Г/А/2017/01/А	Хүлээн авч зочлох, хатуулах, арга хэмжээний нэвтрүүлэг/дугаар	35.0
Нийт дүн				35.0

